

**ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ
ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙНТӨЛӨВЛӨГӨӨНД
ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ
/2018 оны жилийн эцсийн байдлаар/**

2019.02.15

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	13 удаагийн дотоод сургалт Ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн үндсэн, зорилтот, ДТГ-уудад ажиллахаар томилогдсон, томилолтоос эргэж ирсэн ажилтнуудад зориулсан 4 багц бүхий нийт 26 цагийн “Гадаад харилцааны яамны 2018 оны сургалтын төлөвлөгөө”-г Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Дээрх ажлын хүрээнд яамны төв аппаратын нийт албан хаагчдад зориулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар анхаарах асуудал”, “Монгол Улс дахь хүний эрхийн өнөөгийн байдал - Бүх нийтийн боловсролын төлөө!”, хилийн чанад дахь консулын ажилтнуудад зориулсан “Харилцаа, үйлчилгээний соёл, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт цахим сургалтыг тус тус зохион байгуулав. Мөн ДТГ-т ажиллахаар томилолт авсан ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн ерөнхий болон консулын дадлагажуулах сургалтуудыг зохион байгуулав. Түүнчлэн консулын харилцааны чиглэлээр ажиллах дипломат ажилтнуудад зориулж ХЗДХЯ-тай хамтран “Эрх зүйн туслалцаа, ялтан шилжүүлэх”, ЦЕГ-тай хамтран “Хар тамхи, хүн худалдахтай тэмцэх”, УЕПГ-тай хамтран “Прокурорын байгууллагын хамтын ажиллагаа, эрүүгийн хэргийг мөрдөн байцаах үйл ажиллагаа”, НХХЯ-тай хамтран “Гадаадад байгаа иргэдийн нийгмийн хамгааллын асуудал”, ХХЕГ-тай хамтран “Хилийн шалган нэвтрүүлэх	330,000₮ Улсын төсвөөс	

					үйл ажиллагаа болон Монгол Улсын хилээр нэвтрэхэд анхаарах зүйлс”, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран “Монгол-ОУШХБ-ын хамтын ажиллагаа”, ОӨУБЕГ-тай хамтран “Иргэний бүртгэл, лавлагаа, гадаад паспорт, иргэний үнэмлэх захиалга”, ГИХГ-тай хамтран “Виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл”, Нотариатчдын танхим “Нотариатын үйлдэл, үйлчилгээ” сэдэвт нийт 20 цагийн сургалтыг зохион байгуулав. Биелэлт 100%	65,376,226.80₮ Улсын төсвөөс	
		Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	Сургалтуудын ирцийг тухай бүрд нь бүртгэж байсан. Зорилтод бүлгүүдийн оролцоог 80 хувиас дээш байсан. Биелэлт 100%			
		Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	Япон Улс, Израйл Улсад магистрийн сургалтад 3, БНХАУ, БНЭУ, БНСВУ-д чөлөөт худалдааны хэлэлцээр, эдийн засаг, хилийн худалдааны чиглэлээр 44, АНУ-д хууль, эрх зүйн чиглэлээр 7, БНТУ, Сингапур Улс, ИБУИНХУ, Австрали болон бусад улсад дипломатын чиглэлээр 50, Шинэ Зеланд Улс, БНТУ-д гадаад хэлний сургалтад 4, ИБУИНХУ-д орчуулагчийн сургалтад 15 зэрэг давхардсан тоогоор нийт 116 албан хаагчийг тус тус хамруулсан. Биелэлт 100 хувь			
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	Яам, ДТГ-ын ажилтнуудын 96% нь 3-аас дээш жил төрийн албанд ажилласан. Системийн хэмжээнд нийлбэр дүнгээр 82 хувь , Төв аппаратад 135 ажилтан буюу нийт албан хаагчийн 84 хувь, ДТГ-уудад 156 ажилтан буюу нийт албан хаагчийн 80 хувь /яамны үндсэн ажилтнууд/ байдаг. Биелэлт 100 хувь		
Хэсгийн дундаж: 100 хувь							
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	36 ажилтан буюу нийт албан хаагчийн 11 хувь нь дипломат цол, төрийн одон медаль болон салбарын шагналаар шагнагдав. Биелэлт 100 хувь		
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг	Гүйцэтгэлээр	Төрийн үйлчилгээний 4 албан хаагчид ур чадварын нэмэгдэл, ахлах зэргийн нэмэгдэл олгож, мөн Төрийн захиргааны 3 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулав. Биелэлт 100 хувь		

		харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах				
4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	Ажил олгогчоос албан ёсоор сэтгэл ханамжийн асуулга зохион байгуулаагүй. Яамны болон албан хаагчдын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, шинжилгээ хийх ажлыг 2018 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. Нийт албан хаагчдын 50 хувь шинэ байранд ажиллаж байна. Шинэ өргөтгөлд фитнес заал, иогын өрөө зэрэг асуудлыг шийдвэрлэж өгсөн нь албан хаагчдын таашаалд нийцэж байгаа гэж үзнэ. Энэ хугацаанд ажлын байрны тав тухын талаар гомдол санал ажил олгогчид ирүүлж байгаагүй. ТЗУГ-ын зүгээс 00 өрөө, цайны өрөө, харуулын хэсэгт засвар хийж тохижуулаад байна. Мөн албан хаагчдыг бичгийн хэрэгсэл зэрэг ажлын хэрэгцээний материалаар хангахад 2018 онд 38,9 сая төгрөг зарцуулсан байна. Шаардлагатай гэж үзвэл сэтгэл ханамжийн санал асуулгыг ХШҮДАГ-тай хамтран зохион байгуулах боломжтой. Биелэлт 100 хувь		
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	Үнэлэх боломжгүй УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин, хоол унааны зардлыг нэмэгдүүлэхийг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл царцаасан болно.		
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	2018 онд “Интермед” эмнэлэгт 130 албан хаагчийг үнэ төлбөргүй, гэр бүлийн гишүүдийг хөнгөлөлттэй нөхцлөөр эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулсан. Биелэлт 100 хувь	37,768,021 төгрөг	
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	95 хувь		
Хэсгийн дундаж: 100 хувь						
Үнэлгээний дундаж хувь: 100 хувь						